



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

Түр журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, Засгийн газрын 2020 оны "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоолын 23 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэн, харьяатын газрын коронавируст халдвар /Covid-19/-ын цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, байгууллагын үйл ажиллагааг зохицуулах түр журмыг"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/-т даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

000000119

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН КОРОНАВИРУСТ ХАЛДВАР
/COVID-19/-ЫН ЦАР ТАХЛЫН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ

2021 оны 05 сарын 06-ний өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү түр журам нь гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн, өдөр тутмын бэлэн байдлын зэрэг, халдвар тархалтын үеийн түвшин /ногоон, шар, улбар шар, улаан/ тус бүрт уялдуулан Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "байгууллага" гэх/-ын үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтаар хангах, ажлын байранд үйлчлүүлж буй иргэдийн болон албан хаагчийн эрүүл мэндийг хамгаалах, цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Энэхүү "Түр журам" нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол улсын Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалаар баталсан "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллах журам", Улсын онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар баталсан "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж" болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Ажлын тусгай горимд шилжих, цуцлах

2.1. Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн, өдөр тутмын бэлэн байдлын зэрэг, халдвар тархалтын үеийн түвшин /ногоон, шар, улбар шар, улаан/ тус бүрт уялдуулан ажлын тусгай горимд шилжин ажиллана.

2.2. Байгууллагын даргын тушаалаар дэд даргаар ахлуулсан төвийн газар, хэлтсийн төлөөллийг оролцуулсан "Гамшгаас хамгаалах шуурхай штаб" байгуулна.

2.3. Байгууллагын ажлыг тусгай горимд түр шилжүүлэх, албан хаагчдын ээлжээр ажиллах хуваарийг байгууллагын даргын тушаалаар батална.

2.4. Хариуцлагатай эргүүл, жижүүрийн хуваарийг байгууллагын "Гамшгаас хамгаалах шуурхай штаб"-ын дарга батална.

2.5. Эрх бүхий байгууллагаас гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэргийг цуцалсан тохиолдолд тусгай горимд шилжүүлсэн шийдвэрийг хүчингүй болгоно.

2.6. Байгууллагын тусгай горимоор ажиллах үйл ажиллагааг харьяалах хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нар тухайн орон нутгийн онцгой комиссын шийдвэрийг үндэслэн хамтран зохион байгуулах бөгөөд “Гамшгаас хамгаалах шуурхай штаб” болон Захиргаа, удирдлагын газрын дарга нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

Гурав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Тусгай горимоор ажиллах үеийн байгууллагын үйлчилгээний хэлбэр, ажлын хуваарь, анхаарах асуудал, мэдээлэл, лавлагаа өгөх ажилтны албан тушаал, нэр, утас, албаны цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг олон нийтэд байгууллагын цахим хуудсаар дамжуулан ил тод мэдээлнэ.

3.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед байгууллагад ирсэн шуудан, илгээмжийг мэргэжлийн байгууллагаас тогтоосон ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмд нийцүүлэн хүлээн авна.

3.3. Байгууллагаар үйлчлүүлэх иргэдийг эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон зөвлөмж, зааврын дагуу /амны хаалт, нэг удаагийн бээлийтэй байх, “QR” код уншуулахыг шаардах бөгөөд хүн хоорондын зай 1.5-2.0 метр байх/ ажлын байранд нэвтрүүлэх ба иргэдийн явах хөдөлгөөнийг заасан зааварчилгаа, хүн хоорондын зай болон хязгаарлалтын бүсийг тогтоосон тэмдэг, тэмдэглэгээг хийсэн байна.

3.4. Байгууллагаар биечлэн үйлчлүүлсэн иргэдийн талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг /овог, нэр, утас, регистрийн дугаар, оршин суугаа хаяг болон бусад/ томилгоот хариуцлагатай жижүүр хөтөлнө.

3.5. Байгууллагын цахим хаяг, холбоо барих утсыг ажлын цагийн хуваарийн дагуу тогтмол ажиллуулж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллана.

3.6. Ажлын байрны бүх өрөө тасалгаа, хонгил, ариун цэврийн өрөөнд ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаас гаргасан стандарт, зөвлөмжийн дагуу тухай бүр Хангалт үйлчилгээний хэлтэс хариуцана.

3.7. Гамшгаас хамгаалах бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед албан хаагчдыг цахимаар болон ээлжээр ажиллах боломж, мэргэжлийн байгууллагаас өгч буй зөвлөмжийн дагуу коронавируст /мутацлагдсан/ халдвараас хамгаалах нөхцөлийг байгууллагын зүгээс бүрдүүлж, тухай бүр зохион байгуулалт хийнэ.

3.8. Ажлын байранд ажиллах албан хаагчдыг сонгохдоо бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай хүнийг асарч байгаа болон биеийн эрүүл мэндийн байдал зэрэг бусад хүндэтгэн үзэх шалтгааныг харгалзан ажил үүргийн хуваарийг тогтооно.

3.9. Шаардлагатай тохиолдолд ажлын байранд ажилласан албан хаагчдыг албаны нэгдсэн унаагаар авах, хүргэх ажлыг зохион байгуулна.

3.10. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас, хэрэглэл, оношлуурын нөөц бүрдүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгааг Санхүүгийн хэлтэс гаргаж, олгоно.

3.11. Албан хаагчдын дархлааг дэмжих, аарц, чацаргана болон хамгаалах хэрэгсэл /амны хаалт, хамгаалах хувцас, нэг удаагийн резинен бээлий, спиртэн

суурьтай гар ариутгагч/-ээр хангах арга хэмжээг Хангалт үйлчилгээний хэлтэс тогтмол хэрэгжүүлнэ.

3.12. Ажлын байранд болон дайчилгаа, томилгоогоор илүү цагаар, бүх нийтийн баяр, амралтын өдрүүдэд ажилласан албан хаагчдад холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд заасны дагуу нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг олгож болно.

3.13. Байгууллагын нөөц боломжид тулгуурлан мэргэжлийн байгууллагаас тавигдах зохих стандарт, шаардлагад нийцсэн халдварын сэжигтэй тохиолдлыг тусгаарлах өрөөг бэлтгэж, байнгын бэлэн байдлыг хангана.

3.14. Хариуцлагатай эргүүл, жижүүрийг томилж, байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг Хууль зүй, дотоод хэргийн яамны хариуцлагатай жижүүрт тогтоосон цагуудад утсаар болон цахимаар өгч, тэмдэглэл хөтөлж ажиллана.

Дөрөв. Албан хаагчийн нийтлэг эрх, үүрэг

4.1. Албан хаагч ажлын тусгай горимд шилжих үед Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ:

4.1.1. Ажлын тусгай горимд шилжих болсон шалтгаан, нөхцөл байдал, ажил үүргийн хуваарийн талаар мэдээлэл авах;

4.1.2. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөх, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлаа хангах чиглэлээр мэдлэг, дадлага эзэмших;

4.1.3. Ажлын байранд ажил, үүргээ гүйцэтгэх нөхцөл, халдвар хамгааллын нэг удаагийн хэрэгслээр хангуулах, эрүүл мэндээ хамгаалуулах;

4.2. Ажлын тусгай горимд шилжих үед Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан үүргээс гадна дараах үүргийг хүлээнэ:

4.2.1. Ажлын тусгай горимд шилжих үеийн ажиллах нөхцөл, цагийн хуваарь үүргийг хүлээн зөвшөөрч, ажил, үүргээ уялдуулах;

4.2.2. Ажлын тусгай горимд шилжин ажиллах үеийн дүрэм, журам, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил үүргийн хуваарьтай танилцаж, түүнийг хэрэгжүүлдэг байх;

4.2.3. Ажлын тусгай горимд шилжсэнтэй холбогдуулан Засгийн газар, Улсын онцгой комисс, мэргэжлийн байгууллага, удирдлагын зүгээс гаргасан шийдвэрийг биелүүлэх, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд идэвхтэй хамрагдах;

4.2.4. Мэргэжлийн байгууллагаас гаргасан халдвар хамгаалал, ариун цэврийн дэглэм, зааврыг баримтлах, коронавируст /мутацлагдсан/ халдварын аливаа эрсдэлээс өөрийгөө хамгаалах;

4.2.5. Коронавирусын халдвар тээгчтэй ойрын болон дам хавьталд орсон болон биед уг өвчний сэжигтэй шинж тэмдэг /халуурах, ханиах, цээжээр өвдөх зэрэг/ илэрсэн тохиолдолд байгууллагын эмч болон Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвд /119, 80086829 дугаарын утсанд/ тухай бүр яаралтай мэдээлэх, дугаарт хандах;

4.2.6. Шаардлагатай тохиолдолд дайчилгаа, томилгоогоор байгууллагын болон бүх нийтийн хэв журам сахиулах эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэх.

Тав. Бусад

5.1. Энэхүү журмын хэрэгжилтэд төв болон харьяалах хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн дарга нар өдөр тутмын хяналт тавьж, тусгай горимд шилжсэн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ, эрх, үүргийг зөрчсөн албан хаагчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-